



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2022/04-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.selenge@audit.gov.mn
Сүхбаатар сум
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа
Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх
Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитор: О.Анхбаяр
Утас: 7036-2442 Цахим хаяг: ankhbayaro@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт.....	13
3.5.1 Мөнгөн хөрөнгө	13
3.5.2 Авлага	13
3.5.3 Бараа материал.....	14
3.5.4 Үндсэн хөрөнгө.....	15
3.5.5 Өр төлбөр.....	16
3.5.6 Засгийн газрын хувь оролцоо	16
3.5.7 Орлогын данс.....	17
3.5.8 Зардлын данс.....	17
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	18
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	24
3.8 Аудитын гол асуудал	24
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	24
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	25
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	26
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	27
4. Аудитын илрүүлэлт	27
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	33

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БОАЖЯ	Байгаль орчин аялал жуулчлалын яам
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
БҮТЭЗ	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МНБ	Мэргэшсэн нягтлан бодогч
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлэх сан
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЗШ	Төсвийн шууд захирагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
УИХ	Улсын Их Хурал
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин
ХАБ	Хөдөлмөрийн аюулгүй байдал
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв



ЕРӨӨ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Б.СЭРГЭЛЭН ТАНАА

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.03.25 № СЭА-2022/04-НА-СТА-ТТЗ

танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Ерөө сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Ерөө сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

ТТЗ:

- Зайлшгүй шаардлага үүсээгүй байхад төсвийн төлөвлөгөөнөөс давсан орлогоос орон нутгийн хөрөнгө оруулалтын зардлыг **64,700.0** мянган төгрөгөөр нэмэгдүүлэх төсвийн тодотгол өргөн барьж, хэрэгжүүлсэн,

ИТХ:

- Зохион байгуулсан ажил, арга хэмжээнд оролцсон оролцоо, тойрогт ажилласан тухай тайлан, мэдээ зэрэг анхан шатны баримтын бүрдэлгүйгээр сумын ИТХ-ын тэргүүлэгч, төлөөлөгчдөд нийт **26,850.0** мянган төгрөгийн урамшуулал олгосон,

ЗДТГ:

- Урсгал засварын зардлаас үндсэн хөрөнгөд бүртгэлгүй хөрөнгийг /цагдаагийн машин/ засахад **2,620.0** мянган төгрөг зарцуулсан,
- Төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас Бугант-арвижих компанид хүнсний материалын төлбөрийг давхардуулан шилжүүлж, **3,092.4** мянган төгрөгийн авлага үүсгэсэн,

Сумын ЭМТ:

- Үйл ажиллагааны орлогын тооцоог тухай бүр хийж, баталгаажуулаагүйгээс эмийн сангийн эмийн борлуулалтын орлого **341.7** мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн,

Бугант тосгоны Захирагчийн алба:

- Зам засварын ажилд зориулан “БТЕГ” ХХК-иас хандивласан **54,000.0** мянган төгрөгийг сумын ОНХС-ийн дансанд бус нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж, худалдан авах ажиллагаа зарлалгүйгээр гүйцэтгүүлсэн,
- Худалдааны төвийн хуучин барилгыг түрээслүүлсний орлого **5,765.4** мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж, шинэ жилийн баярын үйл ажиллагаанд буюу ахмадуудад хүндэтгэл үзүүлэх, оны шилдгүүдийн шагнал, хүлээн авалт, бэлэг дурсгалын зардалд зарцуулсан,

Бугант тосгоны ЭМТ:

- Ковид-19 өвчнийг илрүүлэх шинжилгээний төлбөр **39,237.5** мянган төгрөгийг кассаар авсан боловч төрийн сан дахь харилцах дансанд тушаалгүйгээр зарцуулсан бөгөөд бүртгэл тайланд тусгаагүй байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.5, 34 дугаар зүйлийн 34.2, 35 дугаар зүйлийн 35.2, 60 дугаар зүйлийн 60.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 14 дүгээр зүйлийн 14.4, ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1, 8 дугаар зүйлийн 8.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ батлах тухай Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2017 оны 216 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ын 7.3 дахь заалтууд болон 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”, Сэлэнгэ аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2012 оны 65 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Сумдын ИТХ-ын тэргүүлэгч, төлөөлөгчдөд урамшуулал олгох журам”-ыг тус тус зөрчсөн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,562,208.01	3,192,577.88
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,673,436.32	1,879,267.68
33	АВЛАГА	383,815.16	659,493.02
35	БАРАА МАТЕРИАЛ	504,956.52	653,817.18
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	10,264,966.26	12,317,009.55
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	10,264,966.26	12,317,009.55
39200	Биет хөрөнгө	9,866,909.64	11,887,881.34
39300	Биет бус хөрөнгө	398,056.62	429,128.21
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	12,827,174.26	15,509,587.42
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	165,567.50	259,703.58
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	165,567.50	259,703.58
41300	Өглөг	165,567.50	259,703.58
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	12,661,606.77	15,249,883.84
51	Засгийн газрын хувь оролцоо	12,661,606.77	15,249,883.84
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	4,217,892.55	4,217,892.55
51200	Хуримтлагдсан үр дүн	5,537,508.07	8,126,137.24
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,906,206.16	2,905,854.05
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	12,827,174.26	15,509,587.42

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	12,082,481.71	10,359,887.50
11	ТАТВАРЫН ОРЛОГО	2,546,059.90	3,114,525.41
110	Орлогын албан татвар	93,822.25	113,426.89
1100	Хувь хүний орлогын албан татвар	93,822.25	113,426.89
113	Хөрөнгийн албан татвар	4,482.00	115,829.57
118	Бусад татвар, төлбөр, хураамж	2,447,755.65	2,885,268.95
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,939,519.90	2,213,387.72
120	Нийтлэг татварын бус орлого	3,939,519.90	2,043,387.72
122	Тусламжийн орлого	0	170,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,596,901.91	5,031,974.36
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	6,876,105.06	6,561,795.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,876,105.06	6,561,795.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,923,367.29	6,321,925.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,873,916.18	3,163,328.01
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	370,880.95	403,813.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	576,241.28	834,379.10
2104	Хангамж, бараа материалын зардал	148,272.41	458,574.68
2105	Нормативт зардал	202,034.49	445,647.85
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	106,791.39	115,342.12
2107	Томиллот, зочны зардал	6,817.90	2,641.63

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	75,384.37	123,595.45
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	563,028.31	774,603.33
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,952,737.78	239,869.94
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	5,206,376.65	3,798,091.98
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	349,985.28	1,209,814.90
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	4,856,391.37	2,588,277.08

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,805,215.40	0.0	7,805,215.40
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,805,215.40	0.0	7,805,215.40
9	Тайлант үеийн үр дүн	4,856,391.37	0.0	4,856,391.37
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	12,661,606.77	0.0	12,661,606.77
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	12,661,606.77	0.0	12,661,606.77
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	352.10	0.0	352.10
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	12,661,958.87	0.0	12,661,958.87
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-352.10	0.0	-352.10
19	Тайлант үеийн үр дүн	2,588,277.08	0.0	2,588,277.08
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	15,249,883.84	0.0	15,249,883.84

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	8,408,833.24	8,621,053.15
11	ТАТВАРЫН ОРЛОГО	2,546,059.90	3,114,525.41
110	Орлогын албан татвар	93,822.25	113,426.89
1100	Хувь хүний орлогын албан татвар	93,822.25	113,426.89
113	Хөрөнгийн албан татвар	4,482.00	115,829.57
118	Бусад татвар, төлбөр, хураамж	2,447,755.65	2,885,268.95
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	83,476.41	176,832.99
1181	Газрын төлбөр	296,172.22	96,146.35
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	2,068,107.02	2,612,289.61
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	222,674.76	580,230.68
120	Нийтлэг татварын бус орлого	222,674.76	410,230.68
122	Тусламжийн орлого	0.00	170,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,640,098.58	4,926,297.06
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,687,768.85	5,959,002.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,687,768.85	5,959,002.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,696,108.84	5,723,090.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,870,098.94	3,108,142.24

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	370,698.81	404,565.91
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	604,634.26	817,228.10
2104	Хангамж, бараа материалын зардал	151,996.15	229,392.45
2105	Нормативт зардал	195,392.62	555,265.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	119,770.24	142,801.59
2107	Томилолт, зочны зардал	6,817.90	2,641.63
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	67,422.38	147,903.36
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	309,277.54	315,149.76
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,991,660.00	235,912.24
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,721,064.39	2,662,050.36
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	546,132.33	2,190,719.01
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	546,132.33	2,190,719.01
2200	Дотоод эх үүсвэрээр	546,132.33	2,190,719.01
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-546,132.33	-2,190,719.01
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-51,780.00	-265,500.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	51,780.00	265,500.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	1,123,152.06	205,831.35
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	550,284.26	1,673,436.32
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,673,436.32	1,879,267.68

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Хэтрэлт /хэмнэлт	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,294,668.30	7,412,584.43	-882,083.87	89.37
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,274,256.10	5,079,653.98	-194,602.12	96.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,176,466.80	4,985,606.23	-190,860.57	96.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,044,278.50	2,962,720.49	-81,558.01	97.32
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	409,087.00	385,132.63	-23,954.37	94.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	806,679.00	805,840.90	-838.10	99.90
2104	Хангамж, бараа материалын зардал	164,066.80	163,087.46	-979.34	99.40
2105	Нормативт зардал	160,444.30	126,159.93	-34,284.38	78.63
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	191,176.50	182,580.74	-8,595.76	95.50
2107	Томилолт, зочны зардал	3,364.90	2,219.10	-1,145.80	65.95
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	129,484.30	93,340.47	-36,143.83	72.09
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	267,885.50	264,524.52	-3,360.98	98.75
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	97,789.30	94,047.75	-3,741.55	96.17
2132	Бусад урсгал шилжүүлэг	97,789.30	94,047.75	-3,741.55	96.17

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,681,262.20	2,067,430.45	-613,831.75	77.11
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	339,150.00	265,500.00	-73,650.00	78.28
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8,294,668.30	7,430,015.16	-864,653.14	89.58
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,109,816.20	3,023,151.71	-86,664.49	97.21
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,196,675.50	3,964,043.16	-232,632.34	94.46
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	68,275.00	48,154.00	-20,121.00	70.53
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	419,901.60	224,666.29	-195,235.31	53.50
36	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	500,000.00	170,000.00	-330,000.00	34.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	2,365.00	9,593.00	7,228.00	405.62
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	14.00	14.00	0.00	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	267.00	267.00	0.00	100.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	1,817.00	1,809.00	-8.00	99.56
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	1,373.00	1,365.00	-8.00	99.42
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	444.00	444.00	0.00	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	267.00	267.00	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	T3 цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	913,254.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	881,382.53
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	810,681.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	145,421.75
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,433.28
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,387.2
2104	Хангамж, бараа материалын зардал	68,547.29
2105	Нормативт зардал	429,105.58
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	49,394.85
2107	Томилолт, зочны зардал	422.53
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	54,562.90
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,406.25
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	70,700.91
2132	Бусад урсгал шилжүүлэг	55,200.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	15,500.91
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	31,872.26
2200	Дотоод эх үүсвэрээр	31,872.26
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	939,862.78
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	939,862.78
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	31,264.19
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	26,608.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Ерөө сумын төсвийн төвлөрүүлэн захирагч- /цаашид Ерөө сумын ТТЗ гэх/-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд анхан шатны баримт, төлбөрийн цахим баримт, өр төлбөр, зардлын данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Анхбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Ерөө сумын ТТЗ нь 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 75 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Ерөө сумын ТТЗ-ийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Иргэн таны оролцоотой эх нутгаа хөгжүүлэе” гэж тодорхойлон байна.

Ерөө сумын ТТЗ нь тайлант онд дараах үйл ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийг хэрэгжүүлэх, сурталчлах, биелэлтийг нь хангах ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах үндсэн дээр хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал сүргийг өсгөн үржүүлэх, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, үржлийн ажлыг зохион байгуулах, байгалийн гэнэтийн аюул, мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлэх,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын, түүнчлэн бүс нутгийн чанартай үйлдвэрлэл, үйлчилгээ, нийгэм-соёлын зориулалттай барилга байгууламж барьж байгуулахад орон нутгийн болон хувийн хөрөнгө оруулалт хийх ажлыг дэмжиж, зохион байгуулах,

- Төрийн ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн ИТХ-д оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийнхээ татварын орлогыг хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Төрийн болон тухайн орон нутгийн өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- Малын тоо толгойн албан татварын тухай хууль 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс шинээр мөрдөгдөхөөр батлагдсан,
- Малын тоо толгойн албан татварын тухай хуультай холбоотойгоор 2020 онд Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр 60 дугаар зүйлийн 60.2.8-д малын тоо толгойн албан татварын орлогыг зарцуулах заалт шинээр нэмэгдсэн,
- Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлд заасан Төрийн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах хэсэгт 2021 оны 7 дугаар сард нэмэлт өөрчлөлт оруулсан,
- УИХ-аас 2021 оны 6 дугаар сард Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан даатгуулагчийн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн доод хэмжээ нь Засгийн газраас баталсан тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тэтгэврийн даатгалд 11.5 хувиас, тэтгэмжийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд тус бүр 1.0 хувиас багагүй байна гэж өөрчлөлт оруулсан,
- Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 2021 оны 43 дугаар тогтоолоор төсөвт зардлыг хэмнэх, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах шаардлагыг төсвийн бүх шатны байгууллагын төсөв захирагч нарт даалгасан,
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах “Босго үнэ шинэчлэн батлах тухай” журмыг баталсан,
- Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам” шинэчлэгдэн батлагдсан,

- Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам” шинэчлэгдэн батлагдсан,
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” шинэчлэгдсэн,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн,
- Аймгийн ТЭЗ-ийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзэж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн зүгээс санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ерөө сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг **1.0** хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 6,876,105.1 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 68,761.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу **48,132.7** мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 1,673,436.3 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 1,879,267.7 мянган төгрөг болж, 205,831.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1 Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/	
			Өсөлт/+, бууралт/-	Дүнд эзлэх хувь
Банканд байгаа бэлэн мөнгө	1,673,436.3	1,879,267.7	205,831.4	10.9
Дүн	1,673,436.3	1,879,267.7	205,831.4	10.9

Эх сурвалж: Ерөө сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд тайлагнагдсан 1,879,267.7 мянган төгрөгөөс орон нутгийн ерөнхий орлогын дансанд 1,639,912.7 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлэлтийн дансанд 15,500.9 мянган төгрөг, ОНХС-ийн дансанд 66,020.3 мянган төгрөг, барьцаа хөрөнгийн дансанд 98,869.6 мянган төгрөг, СХС-ийн дансанд 8,897.3 мянган төгрөг, Бугант тосгоны ЭМТ-ийн харилцах дансанд 23,458.9 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансанд 26,608.0 мянган төгрөг тус тус байршиж байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 360,376.3 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 659,493.0 мянган төгрөг болж, 299,116.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/	
			Өсөлт/+, бууралт/-	
Ажиллагчидтай холбогдсон авлага	183.0	4,028.5	3,845.5	
Зээлийн хүүгийн авлага	26,307.1	28,005.3	1,698.2	
Байгууллагаас авах авлага	16,620.2	127,448.3	110,828.1	
Хувь хүмүүсээс авах авлага	32,716.7	32,621.3	(95.4)	
Хувь хүмүүст олгосон зээл	284,549.3	467,389.6	182,840.3	
Дүн	360,376.3	659,493.0	299,116.7	

Эх сурвалж: Ерөө сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэл 299,116.7 мянган төгрөгөөр өссөн нь СХС-аас 265,500.0 мянган төгрөгийн зээл олгосноос шалтгаалж зээл болон зээлийн хүүгийн авлага 184,538.5 мянган төгрөгөөр, ЭМТ-ийн ЭМДС-аас авах ковидын санхүүжилтийн авлага 104,253.3 мянган төгрөгөөр өссөн зэргээс голлон шалтгаалсан байна.

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 163,563.1 мянган төгрөгийн авлага байгаагаас СХС-ийн 2011-2018 онуудад олгосон эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн зээлийн 108,985.0 мянган төгрөгийн болон зээлийн хүүгийн авлагын 26,307.1 мянган төгрөг зэрэг авлагууд бүртгэлтэй байна.

Тайлант онд хугацаа хэтрүүлсэн СХС-ийн зээлийн 163,563.1 мянган төгрөгийн авлагыг барагдуулахаар 38 иргэний материалыг шүүхэд шилжүүлснээс 8 иргэнтэй “Эвлэрлийн гэрээ” байгуулж, 30 иргэний материал шийдвэрлэх шатандаа явж байна. Сумын Засаг даргын 2021 оны 04-р сарын 06-ны өдрийн удирдамжийн дагуу Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг 1 удаа, Санхүүгийн албаны даргаар ахлуулсан ажлын хэсэг 1 удаа зээлдэгч нэг бүртэй уулзаж хугацаатай мэдэгдлийг удаа дараа өгч 88,229.7 мянган төгрөгийн зээл, хүүгийн авлагыг барагдуулж ажилласан байна.

Аудитын илрүүлэлт:

- **ЕБС нь:** төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас **2,653.2** мянган төгрөгийн, цэцэрлэг нь **1,127.0** мянган төгрөгийн ХХОАТ-ын авлага үүсгэсэн,
- **ЭМТ нь:** НДШ-ийн зардлыг илүү шилжүүлснээс **3,075.1** мянган төгрөгийн авлага үүссэнийг санхүүгийн тайланд тусгаагүй байна.

3.5.3 Бараа материал

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт/-
Тусгай зориулалттай материал	42,665.7	79,770.1	37,104.4
Эм боох материал	27,063.3	17,959.7	(9,103.6)
Бичиг хэргийн материал	198.4	181.7	(16.7)
Аж ахуйн материал	206,084.0	216,548.0	10,464.0
Сэлбэг хэрэгсэл	1,120.0	1,120.0	0.0
Түлш, шатах тослох материал	397.3	102.2	(295.1)
Барилга засварын материал	92,104.6	121,002.2	28,897.6
Хүнсний материал	9,463.5	17,643.1	8,179.6
Бусад хангамжийн материал	107,749.7	182,290.2	74,540.5
Мал амьтад	18,110.0	14,200.0	(3,910.0)
Дүн	504,956.5	650,817.2	145,860.7

Эх сурвалж: Ерөө сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл 145,860.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 1,016,858.1 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн, 832,819.8 мянган төгрөгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн хөрөнгийг орлого авсан, 116,125.5 мянган төгрөгийн хандив тусламж хүлээн авсан, данснаас дансанд 12,954.4 мянган төгрөгийг шилжүүлсэн зэргээр нийт 1,978,757.8 мянган төгрөгөөр нэмэгдэж, 933,769.4 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, 4,350.0 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлэн, 832,819.8 мянган төгрөгийн орон нутгийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлыг ашиглагч байгууллагад шилжүүлэн, 58,957.9 мянган төгрөгийн бараа материалыг акталж, данснаас хассанаас шалтгаалсан байна.

Аудитын илрүүлэлт:

Дараах байгууллагууд бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивээгдээгүй байна. Үүнд:

- **ЕБС: 12,386.2** мянган төгрөгийн хүнсний материал,
- **Цэцэрлэг: 18,558.2** мянган төгрөгийн хүнсний материал,
- **Бугант ЕБС: 17,710.5** мянган төгрөгийн хүнсний материал,
- **Бугант цэцэрлэг: 15,817.7** мянган төгрөгийн хүнсний материал,
- **ИТХ нь: 14,441.9** мянган төгрөгийн бараа материал,
- **ЗДТГ нь: 13,051.8** мянган төгрөгийн бараа материал,
- **ЭМТ нь: 90,707.8** мянган төгрөгийн бараа материал,
- **Ойн анги нь: 2,493.1** мянган төгрөгийн бараа материал,
- **Бугант Захирагчийн алба нь: 53,060.8** мянган төгрөгийн бараа материал,
- **Бугант ЭМТ нь: 28,569.4** мянган төгрөгийн бараа материал тус тус цахим системд шивээгдээгүй байна.
- **Бугант Соёлын төв нь:** Үндсэн хөрөнгийн дансанд **2,282.5** мянган төгрөгийн бараа материалын шинж чанартай хөрөнгийг бүртгэсэн байна.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл /анхны өртгөөр/ 12,455,623.7 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 14,825,111.7 мянган төгрөг болж 2,369,488.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт/-
Барилга, байгууламж, орон сууц	8,964,052.8	9,250,024.6	285,971.8
Хуримтлагдсан элэгдэл	(981,803.1)	(1,224,613.1)	(242,810.0)
Авто-тээврийн хэрэгсэл	632,646.4	1,080,448.3	447,801.9
Хуримтлагдсан элэгдэл	(369,080.4)	(339,846.2)	29,234.2
Машин тоног төхөөрөмж(компьютер)	976,457.5	1,324,182.4	347,724.9
Хуримтлагдсан элэгдэл	(469,171.4)	(488,319.5)	(19,148.1)
Тавилга, аж ахуйн эд хогшил	442,419.0	499,620.6	57,201.6
Хуримтлагдсан элэгдэл	(201,786.3)	(234,515.9)	(32,729.6)
Зам, гүүрний байгууламж	83,438.2	790,600.9	707,162.7
Хуримтлагдсан элэгдэл	(16,174.7)	(18,955.0)	(2,780.3)
Бусад үндсэн хөрөнгө	763,744.8	1,253,328.0	489,583.2
Хуримтлагдсан элэгдэл	(116,810.8)	(164,666.3)	(47,855.5)
Дуусаагүй барилга, байгууламж	53,843.3	53,843.3	-
Ном	105,134.3	106,749.3	1,615.0
Программ хангамж	10,008.0	16,993.0	6,985.0
Хуримтлагдсан элэгдэл	(3,830.8)	(5,186.2)	(1,355.4)
Бусад биет бус хөрөнгө	423,879.4	449,321.4	25,442.0
Хуримтлагдсан элэгдэл	(32,000.0)	(32,000.0)	-
Дүн	10,264,966.3	12,317,009.6	2,052,043.4

Эх сурвалж: Ерөө сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгийн данс нь төсвийн хөрөнгөөр 957,755.8 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн, 1,541,022.3 мянган төгрөгийн хандив тусламж хүлээн авсан, данснаас дансанд 84,221.8 мянган төгрөгийг шилжүүлэн авсан зэрэг 2,582,999.9 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, акталж устгасан 105,949.9 мянган төгрөг, данснаас дансанд шилжүүлсэн 107,562.0 мянган төгрөгөөр хасагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

Дараах байгууллагууд үндсэн хөрөнгөд элэгдэл тооцож, зардлаар хүлээн зөвшөөрч тайлагнаагүй байна. Үүнд:

- **ЗДТГ нь:** 22 нэр төрлийн **38,610.0** мянган төгрөгийн үндсэн хөрөнгөд,
- **ЭМТ нь:** 6 нэр төрлийн **2,149.5** мянган төгрөгийн үндсэн хөрөнгөд,
- **Соёлын төв нь:** 2 нэр төрлийн **1,000.0** мянган төгрөгийн үндсэн хөрөнгөд,
- **Бугант соёлын төв нь:** 3 нэр төрлийн **6,652.5** мянган төгрөгийн үндсэн хөрөнгөд гэх мэт.

3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 142,128.7 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 259,703.6 мянган төгрөг болж, 117,574.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/	
			Өсөлт/+, бууралт/-	Дүнд эзлэх хувь
Ажилчидтай холбогдсон өглөг	4,039.6	42,793.8	38,754.2	90.5
Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.0	81,200.6	81,200.6	100.0
Байгууллагад төлөх өглөг	138,088.6	125,291.6	(12,797.0)	10.2
Хувь хүмүүст төлөх өглөг	0.5	10,417.6	10,417.1	99.9
Дүн	142,128.7	259,703.6	117,574.9	45.3

Эх сурвалж: Ерөө сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны үлдэгдэл 259,703.6 мянган төгрөг болж 117,574.9 мянган төгрөгөөр өссөн нь Ерөө ЭМТ-ийн өглөг 107,866.5 мянган төгрөгөөр, Бугант ЭМТ-ийн өглөг 50,066.9 мянган төгрөгөөр өссөн болон Байгаль хамгаалах, нөхөн сэргээх барьцаа хөрөнгийн өглөг 32,010.0 мянган төгрөгөөр, Ойн ангийн байгууллагад төлөх өглөг 2,420.0 мянган төгрөгөөр, сумын сургуулийн өглөг 1,173.1 мянган төгрөгөөр, сумын ЭМТ-ийн өглөг 4,755.4 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалсан байна.

Аудитын илрүүлэлт:

- **ЗДТГ нь:** ЗДТГ нь албан хаагчдаас суутгасан хоолны төлбөр **1,134.0** мянган төгрөгийг холбогдох байгууллагад шилжүүлээгүй үүссэнийг санхүүгийн тайланд тусгаагүй.

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 12,661,606.8 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 15,249,883.8 мянган төгрөг болж, 2,588,277.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6 Засгийн газрын хувь оролцоо

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт/-	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	4,217,892.5	4,217,892.5	-	-
Хуримтлагдсан үр дүн	5,537,508.1	8,126,137.2	2,588,629.1	31.9
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,906,206.2	2,905,854.1	(352.1)	0.0
Дүн	12,661,606.8	15,249,883.8	2,588,277.0	70.7

Эх сурвалж: Ерөө сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өссөн нь хуримтлагдсан үр дүн 2,588,277.1 мянган төгрөг, өмнөх үеийн үр дүн 352.1 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ.

3.5.7 Орлогын данс

Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд 2020 онд шилжүүлсэн цэцэрлэгийн зураг төсвийн үнэ 46,200.0-ийг буцаан сумын ЗДТГ-т төвлөрүүлсэн, бусад орлогын 1,553.0 мянган төгрөг, Ойн ангийн тусгаарлалтын орлого 116,966.8 мянган төгрөг, Бугант ЭМТ-д 9,920.0 мянган ЭМДС-аас олгосон санхүүжилтийн орлогыг төвлөрүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- **Бугант тосгоны Захирагчийн алба нь:** Бугант тосгоны Захирагчийн алба нь зам засварын ажилд зориулан “БТЕГ” ХХК-иас хандивласан 54,000.0 мянган төгрөгийг сумын ОНХС-ийн дансанд бус нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж, худалдан авах ажиллагаа зарлалгүйгээр гүйцэтгүүлсэн,
- **Бугант ЭМТ нь:** Ковид-19 өвчнийг илрүүлэх оношлуурын шинжилгээний төлбөрийг кассаар авсан боловч Бугант тосгоны ЭМТ нь 39,237.5 мянган төгрөгийг төрийн сан дахь харилцах дансанд тушаалгүйгээр зарцуулж, бүртгэл тайланд тусгаагүй,
- **Ерөө ЭМТ нь:** Эмийн сангийн борлуулалтын тооцоог сар бүр бодож баталгаажуулаагүйгээс 341.7 мянган төгрөгийн эмийн орлогыг дутуу төвлөрүүлсэн,
- **Ковид-19 өвчнийг илрүүлэх оношлуурын 3,981.0 мянган төгрөгийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд орлого орсон тухай бүр бус бөөн дүнгээр тушаасан байна.**

3.5.8 Зардлын данс

Аудитын илрүүлэлт:

- **ТТЗ нь:** Аймгийн төсөвт тодотгол хийгдсэн гэх үндэслэлээр зайлшгүй шаардлага үүсээгүй байхад сумын ИТХ-ын 2021 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн 32 дугаар тогтоолоор төсвийн төлөвлөгөөнөөс давсан орлогоос орон нутгийн хөрөнгө оруулалтын зардлыг 64,700.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн төсвийн тодотгол хийж, зарцуулсан,
- **ИТХ нь:** Зохион байгуулсан ажил, арга хэмжээнд оролцсон оролцоо, тойрогт ажилласан тухай тайлан, мэдээг үндэслэлгүйгээр улирал тутам ИТХ-ын тэргүүлэгчдэд 450.0 мянган төгрөг, төлөөлөгчдэд 300.0 мянган төгрөгөөр тооцож, нийт 26,850.0 мянган төгрөгийн улирлын урамшуулал олгосон,

- **ЗДТГ нь:** урсгал засварын зардлаас тухайн байгууллагын эзэмшилд буюу үндсэн хөрөнгөд бүртгэлгүй хөрөнгийг /цагдаагийн машин/ засахад **2,620.0** мянган төгрөг зарцуулсан,
 - Төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас Бугант-арвижих компанид хүнсний материалын төлбөрийг давхардуулан шилжүүлж, **3,092.4** мянган төгрөгийн авлага үүсгэсэн,
 - **Бугант тосгоны Захирагчийн алба нь:** Бугант тосгоны Захирагчийн алба нь Худалдааны төвийн хуучин барилгыг түрээслүүлсний орлого **5,765.4** мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж, шинэ жилийн баярын үйл ажиллагаанд буюу ахмадуудад хүндэтгэл үзүүлэх, оны шилдгүүдийн шагнал, хүлээн авалт, бэлэг дурсгалын зардалд зарцуулсан,
 - **ЕБС нь:** Эрх бүхий албан тушаалтны тушаал шийдвэргүйгээр захирал Л.Болортуяад төрийн алба хаасны нэмэгдэл, үр дүнгийн урамшууллыг 5 хувиар илүү тооцож, **125.4** мянган төгрөг олгосон,
 - Нягтлан бодогчийн тооцооллын алдаанаас ажилласан цагийн хөлсийг буруу тооцож, 2 багшид **172.1** мянган төгрөгийн цалин илүү олгосон,
 - Танхимын хичээл сургалтын үйл ажиллагаа зогссон үед багш, ажиллагсад **933.4** мянган төгрөгийн илүү цагийн хөлс олгосон,
 - Төсвийн төлөвлөлтийг бодит судалгаа, мэдээлэл дээр үндэслэн зардлын зүйл, эдийн засгийн ангиллаар нь үнэн зөв төлөвлөөгүйгээс нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд **3,909.4** мянган төгрөгийг цалингийн зардлаас санхүүжүүлсэн,
 - **Цэцэрлэг нь:** Арга зүйч Д.Түвшинбаярт орон нутагт ажилласны нэмэгдлийг 15 хувиар тооцон **80.8** мянган төгрөг илүү олгосон,
 - Нягтлан бодогчийн тооцооллын алдаанаас ажилласан цагийн хөлсийг буруу тооцож, туслах багш Л.Батчимэгт **142.9** мянган төгрөгийн цалин илүү олгосон,
 - Нягтлан бодогч Р.Дариймаад ажил хавсран гүйцэтгэж буй цалингаас МНБ-ын нэмэгдэлд **478.6** мянган төгрөгийг олгосон,
 - НДШ-ийн тайланд багш Д.Баярмаагийн хүүхдээ асрах чөлөөтэй байгаа үеийн 2 сарын цалинг тайлагнаагүй,
 - **Бугант ЕБС:** Захирлын 2021 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн А/50 дугаар тушаалаар оны тэргүүнээр шалгарсан 3 багшид дотоод журамд заасан хэмжээнээс илүү тооцон, **325.0** мянган төгрөгийн шагнал олгосон,
 - **Бугант цэцэрлэг:** Дээд шатны төсвийн захирагчийн тушаал шийдвэргүйгээр эрхлэгч П.Баярцэнгэлд ХАБ-ын нэмэгдлийг **96.5** мянган төгрөгөөр илүү олгосон,
- Дараах байгууллагууд төсөвт зохицуулалт хийлгэлгүйгээр буюу дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрөлгүйгээр зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан байна. Үүнд:
- **ЗДТГ нь:** Үндсэн үйл ажиллагааны НДШ-ийн зардлаас гэрээт ажлын НДШ-ийн зардалд 5,438.6 мянган төгрөг,
 - **ЭМТ нь:** Нэмэлт санхүүжилтийн НДШ-ийн зардлаас урсгал үйл ажиллагааны НДШ-ийн зардалд 1,312.6 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулсан,
 - **Ойн анги нь:** Нормын хувцас зөөлөн эдлэлийн зардлаас урсгал засварын зардалд **593.2** мянган төгрөгийг тус тус гүйлгэн зарцуулсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн

5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Ерөө сумын ИТХ-ын “Сэлэнгэ аймгийн Ерөө сумын 2021 оны төсөвт тодотгол хийх тухай” 2021 оны 32 дугаар тогтоолоор тайлант онд 1,764,871.6 мянган төгрөгийн татварын орлого, 206,200.0 мянган төгрөгийн татварын бус орлого, нийт 1,970,981.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 3,300,089.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 167.4 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт №7 Төвлөрүүлэх орлого

Үзүүлэлт	/мянган төгрөг/			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлтийн хувь
Үйл ажиллагааны орлого	70,000.0	16,407.4	(53,592.6)	23.4
Хөрөнгийн орлого	19,736.0	71,922.4	52,186.4	364.4
Хөрөнгө борлуулсны орлого	3,500.0	25,097.0	21,597.0	717.1
Бууны албан татвар	5,100.0	6,306.0	1,206.0	123.6
Малд ногдуулах албан татвар	-	109,523.6	109,523.6	0.0
Улсын тэмдэгтийн хураамж	66,200.0	160,075.2	93,875.2	241.8
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	500.0	12,013.3	11,513.3	2,402.7
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	49,136.0	4,744.5	(44,391.5)	9.7
Газрын төлбөр	52,938.0	96,146.4	43,208.4	181.6
Ойн нөөц ашигласны төлбөр	1,486,693.6	2,605,895.2	1,119,201.6	175.3
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	3,178.0	1,410.0	(1,768.0)	44.4
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	7,800.0	4,984.5	(2,815.5)	63.9
Торгуулийн орлого	150,000.0	140,477.4	(9,522.6)	93.7
Бусад орлого	56,200.0	45,086.9	(11,113.1)	80.2
Дүн	1,970,981.6	3,300,089.8	1,329,108.2	167.4

Эх сурвалж: Ерөө сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн орлогын төлөвлөгөө давж биелэхэд хөрөнгийн орлого 52,186.4 мянган төгрөгөөр, хөрөнгө борлуулсны орлогын албан татвар 21,597.0 мянган төгрөгөөр, малд ногдуулах албан татвар 109,523.6 мянган төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамжийн орлого 93,875.2 мянган төгрөгөөр, газрын төлбөрийн орлого 43,208.4 мянган төгрөгөөр, ойн нөөц ашигласны төлбөрийн орлого 1,119,201.6 мянган төгрөгөөр тус тус давж биелсэн нь голлон нөлөөлсөн байна. Орлогын гүйцэтгэлээр үйл ажиллагааны орлого, хог хаягдлын хураамж, ан амьтны нөөц ашигласны төлбөр, байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр, торгуулийн орлого, бусад орлого зэрэг орлогууд тасарсан байна.

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

Давж биелсэн орлогууд:

- Хөрөнгийн орлого 52,186.4 мянган төгрөгөөр давж биелсэн нь банкны хадгаламжийн хүүгийн орлого нэмэгдсэнээс,
- Хөрөнгө борлуулсны орлогын албан татвар 21,597.0 мянган төгрөгөөр давж биелсэн нь үл хөдлөх хөрөнгийн борлуулалт нэмэгдсэнээс,
- Малын тоо толгойн албан татварыг тайлант онд төлөвлөөгүй боловч гүйцэтгэлээр 109,523.6 мянган төгрөг төвлөрсөн,
- Улсын тэмдэгтийн хураамжийн орлого 93,875.2 мянган төгрөгөөр давж биелсэн нь самрын орлоготой холбоотойгоор /үнэт цаас бичихдээ/ 1 кг тутамд 50 төгрөгөөр тооцож, тэмдэгтийн хураамж тооцож төлүүлснээс,
- Газрын төлбөр 43,208.4 мянган төгрөгөөр давж биелсэн нь 2021 онд шинээр олгогдсон газруудад ноогдуулсан орлого төвлөрсөн,
- Ойн нөөц ашигласны төлбөр 1,119,201.6 мянган төгрөгөөр давж биелсэн нь БОАЖЯ-наас самрын нөөцийг 1380 тн гэж тогтоосны дагуу мэргэжлийн байгууллагуудтай гэрээ байгуулснаа тус тус шалтгаалсан байна.

Тасарсан орлогууд:

- Хог хаягдлын хураамжийн орлого 44,391.5 мянган төгрөгөөр тасарсан нь ЗГ-ын шийдвэрийн дагуу иргэдээс авах хог хаягдлын хураамжийг чөлөөлснөөс,
- Хүү, торгуулийн орлого 9,522.6 мянган төгрөгөөр тасарсан нь уг орлогын гол эх үүсвэр болох уул уурхайн нөхөрлөл, иргэдийн байгаль орчинд учруулсан хохирлын нөхөн төлбөр нь 2021 оноос БОАЖЯ-ны Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн санд төвлөрдөг болсноос,
- Хууль тогтоомжийн дагуу төвлөрөх бусад орлого 11,113.1 мянган төгрөгөөр тасарсан нь үндэслэлгүй төлөвлөлтөөс шалтгаалсан байна.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 13 дугаар тогтоолоор төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нийт орлого, зарлагыг тус бүр 8,179,390.5 мянган төгрөгөөр баталсан байна.

Сумын төсөвт хийгдсэн нийт 1 удаагийн тодотгол болон зохицуулалтаар дараах өөрчлөлтүүд орж сумын төсөв 8,364,106.7 мянган төгрөгөөр эцэслэн батлагдсан байна. Үүнд:

ИТХ-ын 2021 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн 32 дугаар тогтоол:

Дээрх тогтоолоор сумын татварын орлогын төлөвлөгөөг 102,836.0 мянган төгрөгөөр, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтийг 100,580.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн аймгаас олгох санхүүгийн дэмжлэгийг 18,700.0 мянган төгрөгөөр бууруулж тодотгосон байна. Үүнд:

- ЗДТГ-ын тэтгэмж урамшууллын зардлыг 17,207.6 мянган төгрөгөөр бууруулж, Засаг даргын орлогч Э.Одгаравын сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөний тэтгэмжийг 5,340.0 мянган төгрөгөөр, хог хаягдлын үйлчилгээний зардлыг 32,138.5 мянган төгрөгөөр зэрэг нийт 20,270.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн,
- Орон нутгийн хөрөнгө оруулалтын зардлыг Ерөө цэцэрлэгт тоног төхөөрөмж худалдан авах 10,700.0 мянган төгрөг, Ерөө багийн төвийн байрыг халаалтын шугамд холбох 20,000.0 мянган төгрөг, Ерөө сургуульд цахим номын сан

худалдаж авах 20,000.0 мянган төгрөг, Бугант цэцэрлэгт тоног төхөөрөмж худалдан авах 8,000.0 мянган төгрөг, Бугант сургуулийн засварын зураг төсвийн үлдэгдэлд 6,000.0 мянган төгрөг зэрэг нийт 64,700.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн,

- Бугант тосгоны Захирагчийн албаны тэтгэмж урамшууллын зардлыг 17,207.6 мянган төгрөгөөр, гэрэлтүүлэг зардлыг 6,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн,
- Бугант Соёлын төвийн тайз засах урсгал засварын зардлыг 6,657.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн,
- Сумын болон Бугант тосгоны сургуулийн нормын хувцас, зөөлөн эдлэл, урсгал засвар, БҮТЭЗ-ийн зардлуудыг 150,125.4 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн,
- Спорт цогцолбор нь аймгийн төсвөөс санхүүждэг болсноор санхүүжилтийг 28,700.0 мянган төгрөгөөр бууруулсан,
- Цэцэрлэгийн хоол, цалингийн зардлыг 49,545.2 мянган төгрөгөөр бууруулсан,
- ИТХ-ын бараа үйлчилгээний бусад зардлыг 2,000.0 мянган төгрөгөөр бууруулсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 15 хөтөлбөрт зориулан 8,364,106.7 мянган төгрөг төсөв батлагдсанаас аймгийн Засаг даргын 2021 оны А/372 дугаар захирамжаар ТЗШ-ийн байгууллагуудын төсөвт зохицуулалт хийгдэж, тус сумын ТЗШ-ийн байгууллагуудаас нийт 69,438.4 мянган төгрөгийг хасаж 3,109,816.2 мянган төгрөг болгосноос шалтгаалж **8,294,668.3** мянган төгрөг болж өөрчлөгдсөн байна. Батлагдсан төсвийн 5,306,256.1 мянган төгрөгийг урсгал зардалд, 2,649,262.2 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, СХС-ийн зээлд 339,150.0 мянган төгрөгийг зарцуулахаар тогтоожээ.

Нийт зардлын 3,109,816.2 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 477,050.8 мянган төгрөгийг аймгаас авах санхүүгийн дэмжлэгээс, 1,970,981.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1,360,000.0 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс, 68,275.0 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 27,456.0 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос, 388,643.1 мянган төгрөгийг ОНХС-аас, 52,445.6 мянган төгрөгийг ОНХС-ын урьд оны үлдэгдлээс, ОНХС-ын хандиваас 500,000.0 мянган төгрөг, 90,000.0 мянган төгрөгийг СХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс, 250,000.0 мянган төгрөгийг СХС-ийн хандиваар санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 3,023,151.7 мянган төгрөг, аймгаас авах санхүүгийн дэмжлэг 477,050.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 3,098,349.3 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 48,154.0 мянган төгрөг, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 136,436.6 мянган төгрөг, ОНХС-аас 388,643.1 мянган төгрөг, СХС-ийн зээлийн эргэн төлөлт 88,229.7 мянган төгрөг, СХС-ийн хандив 170,000.0 зэрэг нийт **7,430,015.2** мянган төгрөгийн санхүүжилтийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **7,412,584.4** мянган төгрөг буюу 89.4 хувьтай тайлагнагдсан нь эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийг гүйцэтгэлээр нь олгосон, тусгай зориулалтын шилжүүлэг болон орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилтийн хэмнэгдсэн зардлыг татан төвлөрүүлсэн, ОНХС-ийн хандивын санхүүжилт орж ирээгүй зэргээс шалтгаалсан байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулбал цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, ажил олгогчийн НДШ-ийн зардал нийт 105,512.4 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 838.1 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардал 979.3 мянган төгрөгөөр, нормативт зардал 34,284.4 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 8,595.8 мянган төгрөгөөр, албан томилолтын зардал 1,145.8 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж 36,143.8 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 3,361.0 мянган төгрөгөөр, бусад урсгал шилжүүлэг 3,741.6 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардал 613,831.7 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Тайлант онд сумын төсвийн хөрөнгө оруулалт, ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх нийт 34 төсөл, арга хэмжээнд 2,681,262.2 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор батлагдсанаас гүйцэтгэлээр 2,067,430.5 мянган төгрөгийн санхүүжилт олгож, ОНХС-ийн дансанд 66,020.3 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 73,094.6 мянган төгрөг, ЗГНХ, ЗДНХ, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан 13,791.0 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчдаас 109,225.8 мянган төгрөг, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 136,126.9 мянган төгрөг, ЭМДС-ийн нэмэлт орлого 612,280.6 мянган төгрөг зэрэг нийт 944,518.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна. Үүнд:

Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж:

- “БТЕГ” ХХК-иас 54,000.0 мянган төгрөгийг Бугант Захирагчийн албаны зам засварт,
- Иргэн Б.Батсайхан 1,000.0 мянган төгрөг, Гянт болд могойт нөхөрлөл К.Баттогтох 3,000.0 мянган төгрөгийг Ерөө ЭМТ-д,
- Иргэн Б.Одсайхан 1,000.0 мянган төгрөг, төсвийн байгууллагын ажилчид 3,124.7 мянган төгрөгийг Ерөө Соёлын төвийн ойн арга хэмжээнд,
- Хандгайт уул ХХК 5,000.0 мянган төгрөг, иргэдээс 5,969.9 мянган гийг Ковид-19 өвчинтэй холбоотойгоор сумын Онцгой Комиссын үйл ажиллагаанд хандивласан байна.

ЗГНХ, ЗДНХ болон түүнтэй адилтгах хөрөнгөөс:

- Сумын ЗДНХ-өөс ариутгал халдваргүйжүүлэлтэд Ерөө сургууль 1,025.0 мянган төгрөг,
- Ерөө цэцэрлэгт 1,267.5 мянган төгрөг,
- Ерөө Соёлын төвд 120.0 мянган төгрөг,
- Бугант Сургуульд 548.0 мянган төгрөг,
- Бугант цэцэрлэгт 812.5 мянган төгрөг,
- Түргэний машины засварт Бугант ЭМТ-д 5,000.0 мянган төгрөг,
- Ерөө ЭМТ-д 3,500.0 мянган төгрөг,
- Шар усны үерээс хамгаалах ажилд Бугант Захирагчийн албанд 1,518.0 мянган төгрөгийг олгосон байна.

Дээд шатны төсвийн захирагчдаас:

- Аймгийн Статистикийн хэлтсээс мал тооллого, судалгааны зардалд 2,287.0 мянган төгрөг,
- ХХАА-н газраас ургац хураалтын дүн мэдээ нэгтгэх шатахууны зардалд 200.0 мянган төгрөг, махны өргөтгөсөн худалдаанд оролцох 420.0 мянган төгрөг,
- ГБХЗХГ-аас эрүүл гэр бүл сэдэвт сургалтын зардалд 114.5 мянган төгрөг,
- Мал эмнэлгийн газраас малын гоц халдварт шүлхий өвчний шатахууны зардалд 6,000.0 мянган төгрөг,
- Аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтын данснаас замын сангийн 31,970.4 мянган төгрөг,
- БОАЖ-ын газраас сум дундын ойн ангид Биотехникийн ажлын урьдчилгаа санхүүжилт 1,200.0 мянган төгрөг,
- Сумын ЭМТ-үүдэд аймгийн ЭМГ-аас 1 удаагийн буцалтгүй тусламж, шатахуун, томилолтын зардал зэрэгт 56,266.9 мянган төгрөг,
- Боловсролын газраас ариутгал халдваргүйжүүлэлтийн зардалд сургуульд 1,148.0 мянган төгрөг, цэцэрлэгт 434.0 мянган төгрөг, хөтөлбөрийн санхүүжилтэд сургуульд 7,985.0 мянган төгрөг,
- Аймгийн ИТХ-аас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд ИТХ-д 600.0 мянган төгрөг, Бугант Захирагчийн албанд 600.0 мянган төгрөг зэргийг тус тус шилжүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд:

- ЗДТГ нь урьд оны үлдэгдлийн орлого 10,965.1 мянган төгрөг, өвсний үнэ 4,021.0 мянган төгрөг, захиалагчийн хяналтын зардал 4,415.8 мянган төгрөг, хоолны үнэ 397.6 мянган төгрөг, журмын хашааны орлого 313.5 мянган төгрөг,
- Ерөө ЭМТ нь эмийн болон оношлуурын орлогын 55,733.6 мянган төгрөг, Бугант ЭМТ нь эмийн болон оношлуурын орлогын 29,939.7 мянган төгрөг,
- Ерөө Ойн анги урьд оны төвлөрүүлсэн орлого 12,465.9 мянган төгрөг, үнэт цаасны орлого 2,311.9 мянган төгрөг,

- Ерөө сургуульд татан төвлөрүүлсэн санхүүжилт буцаасан 21.0 мянган төгрөг, усны мөнгө 11.5 мянган төгрөг, түрээсийн номын орлого 2,247.8 мянган төгрөг, бусад 1,673.0 мянган төгрөг,
- Бугант сургуулийн микро автобус борлуулсны орлого 200.0 мянган төгрөг, түрээсийн номын орлого 2,852.8 мянган төгрөг,
- Бугант Захирагчийн албаны худалдааны төвийн хуучин барилгыг Мобиком болон иргэдэд түрээслүүлсний орлого 7,206.7 мянган төгрөг,
- Бугант Соёлын төвд талбай түрээсийн орлого 1,350.0 мянган төгрөгийн орлого төвлөрсөн байна.

Эмийн сангийн болон ЭМДС-ийн нэмэлт орлого:

- Ерөө ЭМТ-д эмийн сангийн орлогоор 17,546.2 мянган төгрөг, Ковидын хэвтэн эмчлүүлэх, гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээ, сорьц шинжлэх, дархлаажуулалт зэргээр 513,007.2 мянган төгрөг,
- Бугант ЭМТ-д эмийн сангийн орлогоор 5,525.6 мянган төгрөг, Ковидын гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээ, дархлаажуулалт зэргээр 76,201.5 мянган төгрөгийн санхүүжилт төвлөрсөн байна.

Үүнээс цалин, НДШ-ийн зардалд 169,511.2 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 11,387.2 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 68,547.3 мянган төгрөг, нормативт зардалд 429,105.6 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 49,394.8 мянган төгрөг, томилолтын зардалд 422.5 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 54,562.9 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 32,406.2 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулалд 55,200.0 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 31,872.3 мянган төгрөг тус тус зарцуулж, 15,500.9 мянган төгрөгийг татан төвлөрүүлэн, 26,608.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

- Ерөө ЭМТ нь Сумын Онцгой Комиссын 2021 оны 07 сарын 09-ний өдийн 44 тоот хурлын тэмдэглэлийн дагуу Коронавируст халдвар /КОВИД-19/-ыг илрүүлэх түргэвчилсэн шинжилгээний үнийг 13.0 мянган төгрөгөөр тогтоож, тайлант оныг дуустал нийт 596 иргэнээс уг үнэлгээгээр шинжилгээ авч орлогыг төвлөрүүлсэн нь Монгол Улсын Шадар сайд, Эрүүл мэндийн сайдын 2021 оны хамтарсан 05/А/12-р тушаалын 2 дугаар хавсралтаар тогтоосон “*жишиг үнэ 25.0 мянган төгрөг*”-гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

- Сумын онцгой комисс нь Ковид-19 цар тахалтай тэмцэхэд зориулж иргэд, аж ахуйн нэгжээс хандивласан 10,969.9 мянган төгрөгийг ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж, зарцуулсан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх,

нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хүснэгт №7 ТТЗ-ийн харьяа байгууллагуудын шилэн дансны мэдээлэл

Үзүүлэлт	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн	Хугацаа хоцроосон	Мэдээлээгүй
Засаг дарга	155	103	31	21
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	151	140	11	-
Засаг даргын тамгын газар	151	141	9	1
Эрүүл мэндийн төв	151	105	35	11
Соёлын төв	151	72	75	4
Сум дундын ойн анги	151	68	79	4
Бугант тосгоны захирагчийн алба	151	125	24	2
Бугант тосгоны Эрүүл мэндийн төв	151	103	41	7
Бугант тосгоны Соёлын төв	151	115	33	3
Дүн	1,363	972	338	53

ТТЗ-ийн түвшинд нийт давхардсан тоогоор мэдээлбэл зохих 1,363 мэдээллээс 972 мэдээллийг хугацаанд нь, **338** мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн бол огт мэдээлээгүй **53** мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

1. Ерөө сумын ТТЗ-ийн тайлант оны үйл ажиллагаанд 8,294,668.3 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 7,412,584.4 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг **10.6** хувиар хэмнэсэн нь Засгийн Газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “.....*батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах*” гэж заасныг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Харьяа байгууллагуудын төсвийн хэмнэлт:

- ИТХ нь тайлант оны үйл ажиллагаанд 155,942.6 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 125,639.2 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг **19.4** хувиар хэмнэсэн,

- ЗДТГ нь тайлант оны үйл ажиллагаанд 2,456,353.7 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 2,363,708.9 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг **3.8** хувиар хэмнэсэн,
- Буган тосгоны Захирагчийн алба нь тайлант оны үйл ажиллагаанд 327,954.9 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 327,954.9 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг хэмнээгүй,
- Ойн анги нь тайлант оны үйл ажиллагаанд 81,204.9 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 78,763.6 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг **3.0** хувиар хэмнэсэн.

2. Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4-т: “.....бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх” гэж заасныг дараах байгууллагууд зөрчсөн байна. Үүнд:

- ИТХ нь 2,819.4 мянган төгрөгийн тавилга, эд хогшил,
- Бугант Захирагчийн алба нь 5,000.0 мянган төгрөгийн тавилга, эд хогшил,
- Бугант Соёлын төв нь 6,340.0 мянган төгрөгийн тавилга, эд хогшил худалдан авсан.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 5,174.3 мянган төгрөгийн 4 төлбөрийн акт, 236,482.7 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 6 албан шаардлага, 57,753.3 мянган төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 8. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	4	5,174.3	4	5,174.3	100.0
Албан шаардлага	6	236,482.7	4	89,060.1	66.6
Зөвлөмж	3	57,753.3	3	57,753.3	100.0
Нийт дүн	14	299,410.3	12	299,410.3	85.7

Өмнөх аудитаар өгсөн зайлшгүй шаардлага үүсээгүй байхад төсвийн тодотгол хийхээр өргөн мэдүүлж, батлуулсан, шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зэрэг зөрчлийг арилгах албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйл 42.1-т “...хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэсэн заалтын дагуу сумын Засаг дарга Б.Сэргэлэн болон Санхүүгийн албаны дарга А. Төгсжаргал нарт **сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

3.11.1 Санхүүгийн тайлангийн аудитын цаг хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал байдлын улмаас ОНХС, төсвийн хөрөнгөөр гүйцэтгэгдэж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт, бүртгэл тайлагнал, гүйцэтгэлтэй холбоотой асуудлуудыг бүрэн хэмжээгээр тулган баталгаажуулсан бөгөөд харин төлөвлөлт, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлуудыг Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн, ОНХС-ийн зарцуулалтын үр дүн сэдэвт аудитаар гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай юм.

4. Аудитын илрүүлэлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн шууд захирагчийн 12, орон нутгийн төсөл сангийн 2, нийт 14 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 санхүүгийн тайланд бие даасан дүгнэлт гаргаж, 8 байгууллага, 2 төсөл сангийн тайланг аудитын түүвэрт хамруулсан байна.

Ерөө сумын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 565,194.0 мянган төгрөгийн 38 алдаа, зөрчил илрүүлснээс 11,667.0 мянган төгрөгийн 4 алдааг аудитын явцад залруулж, 2,696.0 мянган төгрөгийн 8 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 214,195.0 мянган төгрөгийн 12 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 336,636.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 13 зөвлөмжийг хүргүүллээ.

Аудит хамрагдсан харьяа 4 байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн байна.

ТТЗ-ийн түвшний аудитаар нийт 464,860.8 мянган төгрөгийн 16 алдаа, зөрчил илрүүлснээс 341.7 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 196,265.3 мянган төгрөгийн 8 зөрчилд албан шаардлага хүргүүлэн, 268,253.8 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 7 зөвлөмжийг хүргүүллээ.

4.1 Төлбөрийн акт:

1. Үйл ажиллагааны орлогын тооцоог тухай бүр хийж, баталгаажуулаагүйгээс сумын ЭМТ нь эмийн сангийн борлуулалтын **341.7** мянган төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2 дахь “Төсвийн байгууллага нь ... өөрийн үйл ажиллагааны орлогыг Төрийн сангийн нэгдсэн дансанд саадгүй байршуулна” гэсэн заалтыг зөрчсөн ба санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дутуу төвлөрүүлсэн орлогыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

4.2 Албан шаардлага:

1. Зайлшгүй шаардлага үүсээгүй байхад сумын ИТХ-ын 2021 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн 32 дугаар тогтоолоор төсвийн төлөвлөгөөнөөс давсан орлогоос орон нутгийн хөрөнгө оруулалтын зардлыг /Ерөө цэцэрлэгт тоног төхөөрөмж худалдан авах 10,700.0 мянган төгрөг, Ерөө багийн төвийн байрыг халаалтын шугамд холбох

20,000.0 мянган төгрөг, Ерөө сургуульд цахим номын сан худалдаж авах 20,000.0 мянган төгрөг, Бугант цэцэрлэгт тоног төхөөрөмж худалдан авах 8,000.0 мянган төгрөг, Бугант сургуулийн засварын зураг төсвийн үлдээгдэлд 6,000.0 мянган төгрөг/ **64,700.0** мянган төгрөгөөр нэмэгдүүлэн төсвийн тодотгол хийж, зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 34 дугаар зүйлийн 34.2 дахь “Засаг дарга дараах тохиолдолд тухайн жилийн төсвийн тодотголыг боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ”, 34.2.2: “Урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, зарлага нэмэгдэж, орон нутгийн төсөв алдагдалтай болох нөхцөл байдал бий болсон” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зайлшгүй шаардлага үүсээгүй байхад урсгал болон хөрөнгийн зардлыг нэмэгдүүлэхээр төсвийн тодотгол хийхгүй байх албан шаардлага хүргүүлэх.

2. Зохион байгуулсан ажил, арга хэмжээнд оролцсон оролцоо, тойрогт ажилласан тухай тайлан, мэдээ зэрэг анхан шатны баримтын бүрдэлгүйгээр улирал тутам сумын ИТХ-ын тэргүүлэгчдэд 450.0 мянган төгрөг, төлөөлөгчдөд 300.0 мянган төгрөг зэрэг нийт **26,850.0** мянган төгрөгийн урамшуулал олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтууд болон аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2012 оны 65 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Сумдын ИТХ-ын тэргүүлэгч, төлөөлөгчдөд урамшуулал олгох журам”-ыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох хууль, эрхийн актын хүрээнд зарлага гаргаж байх албан шаардлага хүргүүлэх.

3. ЗДТГ нь урсгал засварын зардлаас үндсэн хөрөнгөд бүртгэлгүй хөрөнгийг /цагдаагийн машин/ засахад **2,620.0** мянган төгрөг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ын 210604 “Урсгал засвар” “Байгууллага өөрийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй барилга, байгууламж, тээврийн хэрэгсэлд урсгал шинжтэй засвар хийх зориулалтаар бэлтгэсэн материал, сэлбэг, засвар, үйлчилгээний ажлын хөлс энд хамаарна” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлэх.

4. ЗДТГ нь төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас Бугант-арвижих компанид хүнсний материалын төлбөрийг давхардуулан шилжүүлж, **3,092.4** мянган төгрөгийн авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг

зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөр тооцоог урьдчилан хянах замаар авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, үүссэн авлагыг барагдуулах албан шаардлага хүргүүлэх.

5. Бугант тосгоны Захирагчийн алба нь зам засварын ажилд зориулан “БТЕГ” ХХК-иас хандивласан **54,000.0** мянган төгрөгийг сумын ОНХС-ийн дансанд бус нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж, худалдан авах ажиллагаа зарлалгүйгээр гүйцэтгүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь “Орон нутгийн хөгжлийн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ: 60.2.5: тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон **дотоод, гадаадын хандив, тусламж, дэмжлэг.....**”, ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө”, 8 дугаар зүйлийн 8.4 дэх “Тендер шалгаруулалтын журмыг сонгоходоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно” гэсэн заалт болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ батлах тухай Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Орон нутгийн хөгжлийн чиглэлээр аж ахуйн нэгжүүдээс өгсөн хандив тусламжийг ОНХС-ийн дансанд төвлөрүүлж, холбогдох хуулийн дагуу худалдан авах ажиллагаа зарлаж, гүйцэтгүүлж байх албан шаардлага хүргүүлэх.

6. Бугант тосгоны Захирагчийн алба нь Худалдааны төвийн хуучин барилгыг түрээслүүлсний орлого **5,765.4** мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж, шинэ жилийн баярын үйл ажиллагаанд буюу ахмадуудад хүндэтгэл үзүүлэх, оны шилдгүүдийн шагнал, хүлээн авалт, бэлэг дурсгалын зардалд зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2017 оны 216 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ын 7.3 дахь “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг төсвийн хүлээгдэж байгаа гүйцэтгэлд үндэслэн дараах эрэмбийг баримтлан зарцуулна, 7.3.1: Эх үүсвэр дутагдаж байгаа, эсхүл өр төлбөр үүссэн үндсэн үйл ажиллагааны урсгал зардлыг санхүүжүүлэх; 7.3.2: байгууллагын хамт олон, ажилтныг ажлын үр дүнг нь харгалзан урамшуулах, 7.3.3: тухайн салбар болон байгууллагын үйл ажиллагааг дэмжих зориулалт бүхий хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх, 7.3.4: нийт ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэх” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үйл ажиллагааны нэмэлт орлогыг холбогдох хууль, эрхийн актын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлэх.

7. Бугант тосгоны ЭМТ нь ковид-19 өвчнийг илрүүлэх оношлуурын шинжилгээний төлбөрийг кассаар авсан боловч **39,237.5** мянган төгрөгийг төрийн сан дахь харилцах дансанд тушаалгүйгээр зарцуулж, бүртгэл тайланд тусгаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2 дахь “Төсвийн байгууллага нь ... өөрийн үйл ажиллагааны орлогыг Төрийн сангийн нэгдсэн дансанд саадгүй байршуулна”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:”, 14.4.5 “бүх орлого”, 14.4.6 “бүх зардал” гэсэн заалт болон “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 3.12 дэх заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Иж бүрэн байх”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Кассаар авсан орлогыг тухай бүр төрийн сан дахь харилцах дансанд төвлөрүүлж, зарцуулах, орлого, зарлагыг бүртгэл тайланд бүрэн тусгаж байх албан шаардлага хүргүүлэх.

8. Сумын Засаг дарга Б.Сэргэлэн, Санхүүгийн албаны дарга А.Төгсжаргал нар нь өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс алдаа, зөрчлийг давтан гаргасан ба Бугант тосгоны захирагч Д.Эрдэнэбулган нь албан үүргээ хангалтгүй гүйцэтгэснээс төсөв, санхүүгийн холбоотой материаллаг хэмжээний зөрчил гаргасан байна.

Шийдвэрлэсэн нь: Албан үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй зэрэг алдаа зөрчлийг давтан гаргасан сумын Засаг дарга Б. Сэргэлэн, Санхүүгийн албаны дарга А.Төгсжаргал, Бугант тосгоны захирагч Д.Эрдэнэбулган нарт сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэх.

4.3 Зөвлөмж:

4.3.1 Анхан шатны болон цахим төлбөрийн баримттай холбоотой асуудал:

1.1 **Илрүүлэлт:** Тайлант онд ИТХ нь 14,441.9 мянган төгрөгийн, ЗДТГ нь 13,051.8 мянган төгрөгийн, ЭМТ нь 90,707.8 мянган төгрөгийн, Ерөө бүсийн Ойн анги нь 2,493.1 мянган төгрөгийн, Бугант тосгоны Захирагчийн алба 53,060.8 мянган төгрөгийн, Бугант тосгоны ЭМТ нь 28,569.4 мянган төгрөгийн зэрэг нийт **202,324.8** мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

1.2 **Өгсөн зөвлөмж:** Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэж заасныг болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт

юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан “загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

4.3.2 Өр төлбөртэй холбоотой асуудал:

2.1.1 Илрүүлэлт: ЗДТГ нь албан хаагчдаас суутгасан хоолны төлбөр 1,134.0 мянган төгрөгийг холбогдох байгууллагад шилжүүлээгүй нь өөрийн чиг үүрэгт үл хамаарах өр төлбөр үүсгэх эрсдэлтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг зөрчиж байна.

2.1.2 Өгсөн зөвлөмж: 2022 оны 2-р улиралд багтаан холбогдох байгууллагуудтай тооцоо нийлж, дуусгах, цаашид өөрийн чиг үүрэгт үл хамаарах үйл ажиллагаа эрхэлж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.

2.2.1 Илрүүлэлт ЭМТ нь НДШ-ийн зардлыг илүү шилжүүлснээс 3,075.1 мянган төгрөгийн авлага үүссэнийг санхүүгийн тайланд тусгаагүй байна.

2.2.2 Өгсөн зөвлөмж: 2022 оны 2-р улиралд багтаан холбогдох байгууллагуудтай тооцоо нийлж, залруулах.

4.3.3 Зардлын данстай холбоотой асуудал:

3.1 Илрүүлэлт: Төсвийн төлөвлөлтийг бодит судалгаа, мэдээлэл дээр үндэслэн зардлын зүйл, эдийн засгийн ангиллаар нь үнэн зөв төлөвлөөгүйгээс дараах байгууллагууд хөтөлбөр болон зардлын бүлэг хооронд нийт **7,344.4 мянган** төгрөгийг гүйлгэн зарцуулсан зөрчил гаргасан байна. Үүнд:

- ЗДТГ нь үндсэн үйл ажиллагааны НДШ-ийн зардлаас гэрээт ажлын НДШ-ийн зардалд 5,438.6 мянган төгрөг,
- ЭМТ нь нэмэлт санхүүжилтийн НДШ-ийн зардлаас урсгал үйл ажиллагааны НДШ-ийн зардалд 1,312.6 мянган төгрөг,
- Ойн анги нь нормын хувцас зөөлөн эдлэлийн зардлаас урсгал засварын зардалд 593.2 мянган төгрөг,

3.2 Өгсөн зөвлөмж: Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална”, 5.1.2 дахь “Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул зардлыг бодит тооцоо судалгаан дээр үндэслэж, үнэн зөв төлөвлөж, хэрэгжүүлэх.

4.3.4 Үндсэн хөрөнгийн элэгдэлтэй холбоотой асуудал:

4.1 Илрүүлэлт: Дараах байгууллагууд нь 33 нэр төрлийн **48,112.0** мянган төгрөгийн үндсэн хөрөнгөд элэгдэл тооцож зардлаар хүлээн зөвшөөрч тайлагнаагүй байна. Үүнд:

- ЗДТГ-ын 22 нэр төрлийн 38,610.0 мянган төгрөгийн,
- ЭМТ-ийн 6 нэр төрлийн 2,149.5 мянган төгрөгийн,
- Соёлын төвийн 2 нэр төрлийн 1,000.0 мянган төгрөгийн,
- Бугант тосгоны Соёлын төвийн 3 нэр төрлийн 6,352.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4 дэх “*Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:*”, 14.4.6 “*бүх зардал*”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “*Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар*”-ын 4.35 дах “*Элэгдэл нь хөрөнгийн ашиглалтын хугацааны туршид элэгдүүлэх дүнг системтэйгээр хуваарилсан хуваарилалтыг хэлнэ. Тайлангийн үеийн элэгдлийн шимтгэлийг зардал гэж хүлээн зөвшөөрнө*” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

4.2 Өгсөн зөвлөмж: 2022 оны 2-р улиралд багтаан үндсэн хөрөнгийн элэгдлийг нөхөн тооцох.

4.3.5 Бараа материалын данстай холбоотой асуудал:

5.1 Илрүүлэлт: Бугант тосгоны Соёлын төв нь үндсэн хөрөнгийн дансанд **2,282.5** мянган төгрөгийн бараа материалын шинж чанартай хөрөнгийг бүртгэсэн байна. Энэ нь УСНББОУС-17 “*Үндсэн хөрөнгө*”-ийн 13 (б)-д “*Нэгээс дээш тайлангийн хугацааны туршид ашиглагдахаар хүлээгдэж байгаа хөрөнгө юм*” гэж тодорхойлсон заалттай нийцээгүй байна.

5.2 Өгсөн зөвлөмж: 2022 оны 2-р улиралд багтаан бүртгэл, тайланд залруулга хийх.

4.3.6 Мөнгөн кассын ажиллагааны журамтай холбоотой асуудал:

6.1 Илрүүлэлт: Ерөө сумын ЭМТ нь Ковид-19 өвчнийг илрүүлэх оношлуурын **3,981.0** мянган төгрөгийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд орлого орсон тухай бүр бус бөөн дүнгээр тушаасан байна. Энэ нь “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 3.12 дэх “*Эрх бүхий ажилтан хураасан орлогоо өөрийн байгууллагын бүртгэлийн дансанд ажлын 1 хоногт багтаан тушааж сар бүрийн эцэст зарагдсан тасалбарын бүртгэл болон орлого цуглуулсан баримтын (зарагдсан тасалбараас өөрт үлдэх хувь) тооцоог гаргаж, тайланг тушаана*” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

6.2 Өгсөн зөвлөмж: Цаашид тухай бүр өөрийн орлогыг харилцах дансанд тушааж, мөнгөн кассын ажиллагааны журмыг мөрдөн ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс									
						Залруулга		Төлбөрийн акт		Хариуцлага тооцуулах		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал															
1	ТТЗ	СЭА-2022/04-НА-СТА-ТТЗ	Ерөө ЭМТ нь эмийн орлого дутуу төвлөрүүлсэн,	1	341.7			1	341.7						
2	ТТЗ	СЭА-2022/04-НА-СТА-ТТЗ	Зайлшгүй шаардлага үүсээгүй байхад тодотгол хийж, зарцуулсан,	1	64,700.0							1	64,700.0		
3	ТТЗ	СЭА-2022/04-НА-СТА-ТТЗ	Анхан шатны баримтын бүрдэлгүйгээр улирал тутам сумын тэргүүлэгч, төлөөлөгчдөд урамшуулал олгосон,	1	26,850.0							1	26,850.0		
4	ТТЗ	СЭА-2022/04-НА-СТА-ТТЗ	ЗДТГ нь урсгал засварын зардлаас үндсэн хөрөнгөд бүртгэлгүй хөрөнгө засварласан,	1	2,620.0							1	2,620.0		
5	ТТЗ	СЭА-2022/04-НА-СТА-ТТЗ	ЗДТГ нь төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас авлага үүсгэсэн,	1	3,092.4							1	3,092.4		
6	ТТЗ	СЭА-2022/04-НА-СТА-ТТЗ	Бугант тосгоны Захирагчийн алба нь хандивын орлогыг сумын ОНХС-ийн дансанд бус нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж, зарцуулсан	1	54,000.0							1	54,000.0		
7	ТТЗ	СЭА-2022/04-НА-СТА-ТТЗ	Бугант тосгоны Захирагчийн алба нь түрээсийн орлогыг зориулалт бусаар зарцуулсан.	1	5,765.4							1	5,765.4		
8	ТТЗ	СЭА-2022/04-НА-СТА-ТТЗ	Бугант тосгоны ЭМТ нь Кассаар авсан Ковид-19 өвчнийг илрүүлэх оношлуурын шинжилгээний орлогыг бүртгэл тайланд тусгаагүй, төрийн сангийн дансанд төвлөрүүлээгүй.	1	39,237.5							1	39,237.5		
9	ТТЗ	СЭА-2022/04-НА-СТА-ТТЗ	Албан үүргээ хангалтгүй биелүүлсэн болон өмнөх аудитаар өгсөн албан	1								1			

			шаардлагыг хэрэгжүүлээгүй албан тушаалтнуудад сахилгын хариуцлага тооцуулах.												
10	ТТЗ	СЭА-2022/04-НА-СТА-ТТЗ	Бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй,	1	202,324.8								1	202,324.8	
11	ТТЗ	СЭА-2022/04-НА-СТА-ТТЗ	ЗДТГ нь өөрийн чиг үүрэгт хамаарахгүй үйл ажиллагаа явуулснаас өр төлбөр үүсгэх эрсдэлтэй байна.	1	1,134.0								1	1,134.0	
12	ТТЗ	СЭА-2022/04-НА-СТА-ТТЗ	ЭМТ нь НДШ-ийн авлага үүсгэж, бүртгэл тайланд тусгаагүй.	1	3,075.1								1	3,075.1	
13	ТТЗ	СЭА-2022/04-НА-СТА-ТТЗ	Төсвийн төлөвлөлтийг бодит байдалд үндэслэн үнэн зөв төлөвлөөгүй.	1	7,344.4								1	7,344.4	
14	ТТЗ	СЭА-2022/04-НА-СТА-ТТЗ	Үндсэн хөрөнгөд элэгдэл тооцож зардлаар хүлээн зөвшөөрч тайлагнаагүй,	1	48,112.0								1	48,112.0	
15	ТТЗ	СЭА-2022/04-НА-СТА-ТТЗ	Бугант Соёлын төв нь үндсэн хөрөнгийн дансанд бараа материалын шинж чанартай хөрөнгийг бүртгэсэн.	1	2,282.5								1	2,282.5	
16	ТТЗ	СЭА-2022/04-НА-СТА-ТТЗ	Ерөө сумын ЭМТ нь Ковид-19 өвчнийг илрүүлэх оношлуурын орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд орлого орсон тухай бүр бус бөөн дүнгээр тушаасан байна.	1	3,981.0								1	3,981.0	
Дүн				16	464,860.8			1	341.7	1		7	196,265.3	7	268,253.8
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал															
1	ТТЗ	СЭА-2022/04-НА-СТА-ТТЗ	ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалтыг зөрчиж батлагдсан төсвийг 10-аас доош хувиар хэмнээгүй,	1									1		
2	ТТЗ	СЭА-2022/04-НА-СТА-ТТЗ	Шилэн дансны тухай хуулийг зөрчсөн	1									1		
3	ТТЗ	СЭА-2022/04-НА-СТА-ТТЗ	ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4 дэх заалтыг зөрчиж тавилга, эд хогшил худалдан авсан.	1									1		
Дүн				3									3		
Нийт дүн				19	464,860.8			1	341.7	1		10	196,265.3	7	268,253.8